



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

### XXXIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXIV дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 20.00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 98 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэр гаргаж, үүрэг даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамны мэдээлэл (Коронавируст халдварын хүн амын дунд бүртгэгдсэн дэгдэлтийн цар хүрээ тэлэх эрсдэлийн үнэлгээ)

Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

2. Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян

3. Бусад

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, Г.Сайханбаяр,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян

Зам тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн М.Мөнхсайхан,

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Г.Өнөрбаяр,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,  
бригадын генерал Ж.Бямбасурэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн. Улсын ерөнхий байцаагч Т.Гантулга,  
Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

- 1.1. Коронавируст халдварт бүртгэгдсэнтэй холбогдуулан салбар дундын эрсдэлийн үнэлгээний баг коронавируст халдварт хүн амын дунд тархах эрсдэлийг үнэлэхэд "Өндөр эрдэлтэй" байгаа тул "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэргээс "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал"-ын зэрэг шилжүүлэхээр шийдвэрлэсэн тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын тогтоол гаргуулах;
- 1.2. Монгол Улсад коронавируст халдварт илэрсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотын орох, гарах бүх нийтийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хатуу хөл хорио тогтоон холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- 1.3. Төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлэх;
- 1.4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхтэй холбогдуулан:
  - Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа
  - Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа
  - Газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
  - Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа
  - Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл ханганд нийлүүлэх үйл ажиллагаа
  - Банкны төлбөр, тооцооны үйл ажиллагаа
  - Хэвлэл мэдээлэл, цахилгаан холбоо, шуудангийн үйл ажиллагаа
  - Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
  - Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа
  - Шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаа
  - Оршуулгын зэрэг үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн ажиллах нөхцөлийг хангах;
- 1.5. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Гамшигийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах" журамд заасны дагуу холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүд.

Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

2.1. Коронавируст халдвартын хүн амын дунд тархах эрсдэлийн түвшин нэмэгдсэнтэй холбогдуулан Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалын дагуу аймаг, нийслэлийн түвшинд коронавируст халдвартын эрсдэлийн үнэлгээг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангах;

2.2. Халдвартын голомтод болон хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа тусгай чиг үүргийн байгууллагын алба хаагчид, бүх шатны шуурхай штабын бүрэлдэхүүнд халдварт өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Гурав. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын орлогч дарга, Г.Сайханбаяр.

Хүнс. хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, Улсын ерөнхий байцаагч Т.Гантулга,

Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

3.1. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, борлуулалтын байдал, нөөц, үлдэгдлийн хөдөлгөөнд өдөр тутамд хяналт тавьж, нийлүүлэлтийн болон үнийн түвшинг тогтвортой байлгах, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэх, хэт нөөцлөх, дамлан худалдаалаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

Я.СОДБААТАР

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ